

ТӨРИЙН ТУСГАЙ ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Ж.Бундхорол

ДХИС-ийн Удирдлагын академийн 2022-7081 дүгээр дамжааны суралцагч,
ахлах дэслэгч

Товч агуулга: Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлыг хангахад тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын хамтын ажиллагаа сэдвийн хүрээнд Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах, болзошгүй эрсдэл, аюулаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхийг зорилгоо.

Түлхүүр үгс: Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдал, чиг үүрэг, тусгайлсан чиг үүрэг, хамтын ажиллагаа, аюул, занал.

Оршил. Үндэсний аюулгүй байдал нь үндэсний батлан хамгаалах болон эдийн засгийн аюулгүй байдлыг зэрэг агуулж байдаг. Өөрөөр хэлбэл,

хүн амынхаа нийгмийн болон эдийн засгийн сайн сайхан байдлыг хангаж байгааг хэлнэ

Монгол Улсын иргэн бүр, түүний дотор төрийн албаны бүх шатны албан хаагчид, аюулгүй байдлын асуудлаар өргөн мэдлэг, мэдээлэлтэй байж үндэсний аюулгүй байдлыг хангах үйлсэд бодит хувь нэмэр оруулах зайлшгүй шаардлагатай.

Нэг. Үндэсний аюулгүй байдлын онолын үндэс

Аюулгүй байдал гэдэг нь хүн, нийгэм, бусад субъект, объект, тэдгээрийн системийн хамгаалагдсан байдал, эрсдэлийн бага түвшнийг илэрхийлдэг олон талт, харьцангуй ойлголт юм. Аюулгүй байдал гэдгийг энгийнээр тодорхойлбол аюул байхгүй, өөрөөр хэлбэл хэн нэгэн эсвэл ямар нэгэн зүйлд хэн нэгнээс эсвэл ямар нэгэн зүйлээс аюул занал учруулахгүй байх нөхцөл, болзошгүй аюулаас хамгаалагдсан байдал гэж ойлгож болно.

Аюулгүй байдалд шинжлэх ухааны бүхий л цогц асуудлыг багтааж үзэх зорилгоор эрдэмтэд аюулгүй байдлын шинжлэх ухааныг “секьюритологи” хэмээн нэрлэх нь

оновчтой гэж үзсэн байна. “Секьюритологи” гэсэн нэр томъёо нь секьюрити (securitas)-аюулгүй байдал гэсэн латин үг, logos-сургаал, шинжлэх ухаан гэсэн грек үгний нийлбэр бөгөөд орчуулбал “аюулгүй байдлын шинжлэх ухаан” гэсэн агуулгыг илэрхийлнэ гэж үзжээ.

Аюулгүй амьдрах хүсэл, сонирхлын үндсийг философичид эрт үеэс тухайлбал, нийтийн тооллоос хэдэн зуун жилийн өмнө амьдарч байсан хятадын Сүнз, грекийн Сократ, Платон, Аристотель нараас эхлээд Н.Макиавелли, Т.Гоббс, Ж.Локка, Ш.Монтескье, Д.Дидро, Б.Спиноза нарын философийн үзэл баримтлалд тусгагдсаар ирсэн түүхтэй.

XVII-XVIII зуунд Баруун Европын орнуудад “аюулгүй байдал” хэмээх ойлголт өргөн хүрээнд тархаж эхэлсэн бөгөөд аливаа бодит аюул занал арилсан нөхцөлд бүрэлдэн тогтсон энх тайван, амар амгалан байдал, түүнд нөлөөлсөн улс төр, эдийн засаг, материаллаг нөхцөл гэж үздэг байв. Үүнд Т.Гоббс, Ж.Ж.Руссо, Б.Спиноза

нарын философийн үзэл баримтлал нөлөөлсөн байна¹.

Эдийн засаг, улс төр, хүрээлэн буй орчин, цэргийн зэрэг аюулгүй байдлын олон талт бүтэц нь хэдийгээр бусад салбар шинжлэх ухааны боловсруулах асуудал мөн боловч шинжлэх ухааны салбар бүхэн аюулгүй байдлын ерөнхий онолыг боловсруулахад өөр өөрийн хувь нэмрийг оруулдаг.

Дэлхий ертөнц, хүн төрөлхтний амар амгалан, хөгжил дэвшилд заналхийлж байгаа болон заналхийлж болзошгүй аюулыг судалж, сулруулж саармагжуулах, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох асуудалд улс орон бүрийн төрийн бодлого, үйл ажиллагаа чиглэгдэж ирсэн. Иймд аюулгүй байдлыг хангах асуудлыг шийдвэрлэх шинжлэх ухааны салбар нь бусад шинжлэх ухааны ололтод тулгуурлан хөгжиж байна.

Аюул, заналаас урьдчилан сэргийлэх, түүнийг саармагжуулах, таслан зогсоох цогц асуудлыг авч үзэхдээ аюулгүй байдлын ерөнхий онолд үндэслэдэг. Аюулгүй байдлын ерөнхий онол нь чиглэл бүрээр судалгаа, шинжилгээ явуулдаг аюулгүй байдлын салбар онолуудыг ерөнхий онол, арга зүйн үндсээр хангаж өгдөг, аюулгүй байдлын асуудлаарх гүн ухааны болоод ертөнцийг танин мэдэх арга зүйн шинжлэх ухаан юм.

Чиглэл бүрээр судалгаа, шинжилгээ явуулдаг аюулгүй байдлын салбар онол хөгжихийн хэрээр аюулгүй байдлын ерөнхий онолын үүрэг өсөн нэмэгдэж, дараах асуудалд анхаарлаа төвлөрүүлэх шаардлага, хэрэгцээг үүсгэж байна. Үүнд:

- Аюулгүй байдлын салбар онолуудын хамгийн нийтлэг, түгээмэл шинж төрхийг илрүүлж, тэдгээрт тулгуурлан ойлголт, зүй тогтол, байгаль, нийгмийн хуулийг нээх;

- Аюулгүй байдлын төрөл бүрийн онолын хөгжлийн түвшнийг тодорхойлж, тэдгээрийг эрэмбэлэн ангилж, эрэлт, хэрэгцээнд чиглэсэн шинжлэх ухааны мэдлэгт дүн шинжилгээ хийх;

- Салбар онолуудын аюулгүй байдлын асуудлыг үр дүнтэй боловсруулах арга барил, үнэлгээ, сонголтын асуудлыг шийдвэрлэх;

- Аюул, заналын гарал үүсэл, агуулга, мөн чанарт гүн ухаан, нийгэм, улс төр судлалын үүднээс үнэлгээ, дүгнэлт хийж, аюулгүй байдлын тогтолцоо, түүнийг хангах арга замыг судлах.

Аюулгүй байдал судлалд холбогдох шинжлэх ухааны ерөнхий онол болон түүнд холбогдох салбар шинжлэх ухааны онолыг ялгаж ойлгосноор аюулгүй байдлыг хангах арга зүйн үндэс тавигддаг байна. Үүнийг дараах хүснэгтээр илэрхийллээ.

Хүснэгт №1. Шинжлэх ухааны харьцуулалт

Аюулгүй байдал судлалд холбогдох шинжлэх ухааны ерөнхий онол	Аюулгүй байдал судлалд холбогдох салбар шинжлэх ухааны онол
• Гүн ухаан • Нийгэм судлал • Улс төр судлал • Сэтгэл судлал • Тогтолцооны онол	• Цэргийн шинжлэх ухаан • Газар хөдлөлт • Эрүүл мэндийн шинжлэх ухаан • Хөдөлмөрийн аюулгүйн онол • Найдвартай байдлын онол

¹ Ж.Бор, Д.Баатар (2016), "Монголын аюулгүй байдал" УБ, 51 дэх тал.

• Эдийн засгийн ухаан • Хууль зүйн ухаан	• Эрсдэлийн онол • Сүйрлийн онол
---	---

Эх сурвалж: Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдал (Онол, практикийн асуудлууд), УБ,2022

Аюул нь улс, нийгэм, хувь хүн болон ямар нэгэн объект, тогтолцооны бүтэц, үйл ажиллагааг алдагдуулах хүчин зүйлийг бодитой агуулдаг, хохирол учруулах, устгах чадвар бүхий далд оршиж буй хүч.

Занал нь аюул хэмээх ойлголттой гарвал нэгтэй, илэрхий, ил тодорхой болсон аюулаар илэрхийлэгдэх бодит байдал бөгөөд улс, нийгэм, хувь хүн, амьтай бүхнийг айдас, хүйдэст хүргэдэг үзэгдэл¹.


Энэ нь нийгэм, хувь хүн, улс гүрэн аюул, заналаас хамгаалагдсан байдлыг

аюулгүй байдал хэмээн үзэх хандлага байдаг. Гэхдээ энэ тодорхойлолт нь аюулгүй байдал гэсэн ойлголтыг “хамгаалагдсан байдал” гэсэн томъёоллоор явцуу агуулгыг илэрхийлж, дайралт, довтолгооноос хамгаалах, тэмцэл явуулах үйл ажиллагааг орхигдуулсан сөрөг талтай юм.²

1. Үндэсний аюулгүй байдал, Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо

Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг гэж тодорхойлдог.

Хүснэгт №2. Үндэсний аюулгүй байдлын ангилал



Эх сурвалж: Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдал (Онол, практикийн асуудлууд), УБ,2022

Үндэсний аюулгүй байдлын тогтолцоо нь үндэсний язгуур эрх ашиг сонирхол, аюул заналхийллийн харилцан үйлчлэлийг тодорхойлсон функциональ тогтолцоо байдаг тул дараах хоёр үүргийн хэрэгжүүлдэг. Үүнд:

- Үндэсний аюулгүй байдлыг хангах хүчин - төрийн цэргийн байгууллага, түүн дотроо Зэвсэгт хүчин, хилийн цэрэг болон гамшгаас

хамгаалах, хууль сахиулах чиг үүрэг бүхий бусад байгууллага, түүнчлэн хууль тогтоомжийн дагуу улсын үндэсний аюулгүй байдлыг хангахад оролцож буй төрийн байгууллагууд;

- Үндэсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгсэл - төрийн тухай мэдээллийг цуглуулах, бүрдүүлэх, боловсруулах, дамжуулах, хүлээн авах үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоонд ашигладаг технологи, түүнчлэн техник, программ хангамж, хэл шинжлэл, хууль эрх зүй, зохион байгуулалтын хэрэгсэл, түүний дотор

¹ “Батлан хамгаалах стратеги (2017)”, УБ хот, 60-61 дахь тал.

² Ч.Улаанхүү (2016), “Аюулгүй байдлын үндэс”, УБ хот, 30 дахь тал.

үндэсний аюулгүй байдал, түүнийг бэхжүүлэх арга хэмжээг бэхжүүлэх харилцаа холбооны суваг багтдаг.¹

2. Төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын хамтын ажиллагаа

Төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагыг Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу дараах байдлаар авч үзнэ. Үүнд:

7.1.Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагууд:

7.1.1.Байгаль орчныг хамгаалах алба;

7.1.2.Гаалийн алба;

7.1.3.Дипломат алба;

7.1.4.Гамшгаас хамгаалах алба;

7.1.6.Зэвсэгт хүчин, бусад цэрэг;

7.1.7.Татварын алба;

7.1.8.Тусгай алба;

7.1.9.гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба;

7.1.10.иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн алба.

7.1.11.цагдаагийн алба.

7.2.Төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагууд өөрсдийн бүрэн эрхийн хүрээнд үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцож, хамтран ажиллах үүрэгтэй².

Мөн тусгайлсан чиг үүрэгтэй төрийн байгууллагууд нь хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулж, хамтран ажиллах үүрэгтэй.

Байгаль хамгаалах алба: хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилгоор байгаль орчинд хортой нөлөөлөхөөс болон байгаль орчны тэнцэл алдагдахаас сэргийлэн хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Гаалийн алба: Монгол Улсын гадаад худалдааны үйл ажиллагаанд

дүн шинжилгээ хийх, төсвийн орлогын бүрдүүлэлт болон гаалийн хилээр нэвтрүүлэх барааны хөдөлгөөнд хяналт тавих, бусад үүргийг хэрэгжүүлнэ.

Дипломат алба: Монгол Улсын тусгаар тогтнол, төрийн бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг олон улсын харилцааны түгээмэл зарчим, эрх зүйн хүрээнд баталгаажуулах зэрэг үүрэгтэй болно.

Гамшгаас хамгаалах алба: Үндэсний аюулгүй байдалд ноцтой хохирол учруулахуйц гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал тохиолдсон үед Монгол Улсын Их Хурал уг асуудлыг дараалал харгалзахгүйгээр нэн яаралтай хэлэлцэж, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг гаргана.

Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх удирдамжийг боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх, гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон болон аюулын нөхцөл байдлын талаар хүн амд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан, эсхүл шууд мэдээлэх, заавар, зөвлөмжөөр хангах болон бусад үүргийг хэрэгжүүлнэ.

Төрийн цэргийн байгуулал: Монгол Улсын зэвсэгт хүчин улсыг цэргийн хүч, хэрэгслээр батлан хамгаалах зорилго бүхий төрийн цэргийн байгууллага. Төрийн цэргийн байгууллагууд нь эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, халдашгүй дархан байдлыг гаднын зэвсэгт халдлага, түрэмгийллээс өөрийгөө хамгаалах үндсэн чиг үүрэгтэй юм.

Татварын алба: Улсын төсвийн орлогыг төлөвлөсөн хэмжээнд бүрдүүлэх үүрэгтэй болно.

Тусгай алба: Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах,

¹ Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдал (Онол, практикийн асуудлууд), УБ, 2022

тусгай албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, үндэсний аюулгүй байдлыг тагнуулын аргаар хангах бодлого боловсруулж хэрэгжүүлэх үүрэгтэй.

Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба: Монгол Улсад оршин суух, түр хугацаагаар зорчих гадаадын иргэдийн зохистой харьцааг бий болгох, гадаадын иргэн, харьяалалгүй хүнд Монгол Улсын виз, визийн зөвшөөрөл олгох, тус улсад байх визийн хугацааг сунгах, визийг хүчингүй болгох, хяналт тавих, илэрсэн зөрчлийг шийдвэрлэх үүргийг хэрэгжүүлнэ.

Иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн алба: Монгол Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, улсын бүртгэлийн үйл ажиллагааны талаар гадаад улс, олон улсын бүртгэлийн болон төрөлжсөн бусад байгууллагатай Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээний дагуу хамтран ажиллах, Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, тэдгээрийн харьяа байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй.

Цагдаагийн алба: Цагдаагийн алба гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд хэрэгжүүлэх буюу нийгмийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй болно.

Дүгнэлт

Төрийн байгуулал, засаглалын чадавхыг боловсронгуй болгох, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, иргэдийнхээ эрүүл, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, хүрээлэн буй орчин, уламжлал, зан заншлаа

хамгаалахтай холбоотой олон шинэ асуудлууд тулгамдаж байна.

Улс орнуудын хамтын ажиллагаа өсөн нэмэгдэж байгаа энэ үед ертөнц, хүн төрөлхтний амар амгалан, хөгжил дэвшилд заналхийлж байгаа болон заналхийлж болзошгүй аюулыг судалж, сулруулж саармагжуулах, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох асуудалд улс орон бүрийн төрийн бодлого, үйл ажиллагаа чиглэгдэж ирсэн. Иймд аюулгүй байдлыг хангах асуудлыг шийдвэрлэх шинжлэх ухааны салбар нь бусад шинжлэх ухааны ололтод тулгуурлан салбарын онцлогийг харгалзаж төсөл хөтөлбөр боловсруулах шаардлага үүсэж байна гэж дүгнэх боломжтой.

Санал

Судалгааны ажлаараа, сэдвийн хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

Улс оронд тулгарч буй асуудал, аюул, заналын гарал үүсэл, агуулга, мөн чанарт гүн ухаан, нийгэм, улс төр судлалын үүднээс үнэлгээ хийхэд мэргэжлийн шинжээчдийг ажиллуулах

Аюулгүй байдлын хамтын ажиллагааны хүрээнд аюулгүй байдлыг хангах ажлын дүгнэлт хийж, аюулгүй байдлын тогтолцоо, түүнийг хангах арга замыг нарийвчлан боловсруулах зэрэг болно.

Эх сурвалжийн жагсаалт

- Ж.Бор, Д.Баатар (2016), “Монголын аюулгүй байдал” УБ хот.

- “Батлан хамгаалах стратеги (2017)”, УБ хот

- Ч.Улаанхүү (2016), “Аюулгүй байдлын үндэс”, УБ хот.

- Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдал (Онол, практикийн асуудлууд), УБ хот, 2022

- Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, 2001, <https://legalinfo.mn/mn/detail/18>